



Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн
захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын
2025 оны 4 дүгээр улирлын шилэн дансны үйл
ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан 29/02 дугаар удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын 2025 оны 4 дүгээр улирлын шилэн дансны үйл ажиллагаанд 207 байгууллага нь 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 32916 мэдээлэл байршуулах ёстойгоос 97,5% буюу 32,108 мэдээллийг хуулийн хугацаанд, 2,3% буюу 768 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 0,1% буюу 40 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 97,5% гарлаа.



Мэдээлэл хугацаандаа байршуулалтыг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Мэдээлэл байршуулалтыг байгууллагын төрлөөр нь ангилан харуулбал:

Боловсролын салбарын 82 байгууллага 4 дүгээр улирлын байдлаар нийтдээ 13612 мэдээлэл байршуулах ёстойгоос 13359 мэдээллийг хуулийн хугацаанд, 232 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 21 байгууллага 21 мэдээллийг (Худалдан авах

ажиллагааны тайлан) огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 98,1% гарлаа

Соёлын салбарын 23 байгууллага 4 дүгээр улирлын байдлаар нийтдээ 3818 мэдээлэл байршуулах ёстойгоос 3748 мэдээллийг хуулийн хугацаанд, 67 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 байгууллага 3 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 98,2% гарлаа.


Эрүүл мэндийн салбарын 21 байгууллага 4 дүгээр улирлын байдлаар нийтдээ 2838 мэдээлэл байршуулах ёстойгоос 2768 мэдээллийг хуулийн хугацаанд, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 97,5% гарлаа.

Орон нутгийн төсвийн 48 байгууллага 4 дүгээр улирлын байдлаар нийтдээ 7968 мэдээлэл байршуулах ёстойгоос 7752 мэдээллийг хуулийн хугацаанд, 213 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 байгууллага 3 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 97,3%.


20 төрийн сан 4 дүгээр улирлын байдлаар нийтдээ 2840 мэдээлэл байршуулах ёстойгоос 2697 мэдээллийг хуулийн хугацаанд, 142 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 байгууллага 1 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 95% гарлаа.

Орон нутгийн өмчит 13 байгууллага 4 дүгээр улирлын байдлаар нийтдээ 1840 мэдээлэл байршуулах ёстойгоос 1784 мэдээллийг хуулийн хугацаанд, 44 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 байгууллага 12 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 97,0%.

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар шилэн дансны улирлын мэдээг хуулийн хугацаанд илгээлт 82,7% буюу 167 байгууллага, хугацаа хоцорч илгээсэн 8,9% буюу 18 байгууллага, огт илгээгүй 7,9% 16 байгууллага, хянагдаагүй 0,5% буюу 1 байгууллага байна. Улирлын мэдээ илгээлтэд хамаарахгүй 5 байгууллага байна (4 өрхийн эмнэлэг, Ахмадын өргөө). Улирлын мэдээ илгээлтийг хуулийн хугацаанд илгээлгэх зорилгоор манай байгууллагаас “Шилэн дансны улирлын мэдээ илгээлтийн хугацаа”-аар шторк хийж байгууллагын цахим хаягт байршуулсан.



Хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлтийг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Улирлын мэдээ илгээлтийг салбар тус бүрээр авч үзвэл:

Боловсролын салбарын 82 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 69 байгууллага, хугацаа хоцроож мэдээ илгээсэн 6 байгууллага, огт илгээгүй 6 байгууллага, хянагдаагүй 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 84,1%.

Соёлын салбарын 23 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 18 байгууллага, хугацаа хоцроож мэдээ илгээсэн 3 байгууллага, огт илгээгүй 2 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 78,3%.

Эрүүл мэндийн салбарын 21 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 12 байгууллага, хугацаа хоцроож мэдээ илгээсэн 4 байгууллага, огт илгээгүй 1 байгууллага. Улирлын мэдээ илгээлтэд 4 өрхийн эмнэлэг хамаарахгүй. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 70,6%.

Орон нутгийн төсвийн 48 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 41 байгууллага, хугацаа хоцроож мэдээ илгээсэн 4 байгууллага, огт илгээгээгүй 3 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 85,4%.

20 төрийн сангийн улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 19 байгууллага, огт илгээгүй 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 95%.

Орон нутгийн өмчит 13 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 8 байгууллага, хугацаа хоцроож мэдээ илгээсэн 1 байгууллага, огт илгээгүй 3 байгууллага байна. Улирлын мэдээ илгээлтэд Ахмадын өргөө хамаарахгүй. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 66,7%.

Байгууллагын таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг байршуулалтад Орон нутгийн төсөвт байгууллагыг 100% буюу 48 байгууллага, түүврээр боловсролын 30

байгууллага, эрүүл мэндийн 8 байгууллага, соёлын 11 байгууллага нийт 97 байгууллагыг хамруулж хяналт хийхэд нийт 20,482,447,616 (хорин тэрбум дөрвөн зуун наян хоёр сая дөрвөн зуун дөчин долоон мянга зургаан зуун арван зургаа) төгрөгийн мэдээлэл байршуулахаас 20,421,241,977 (хорин тэрбум дөрвөн зуун хорин нэгэн сая хоёр зуун дөчин нэгэн мянга есөн зуун далан долоо) төгрөгийн мэдээлэл байршуулж, 6 байгууллага 61,205,639 (жаран нэгэн сая хоёр зуун таван мянга зургаан зуун гучин ес) төгрөгийг байршуулаагүй байна. Мэдээллийг 91 байгууллага буюу 93,8% нь бүрэн байршуулж, 4 байгууллага буюу 4,1% нь мэдээллийг дутуу байршуулж, 2 байгууллага буюу 2,1% нь мэдээлэл огт байршуулаагүй шилэн дансанд оруулах мэдээлэл байхгүй гэж **Худал** мэдээлжээ. Мэдээллийг дутуу болон огт байршуулаагүй байгууллагуудыг доорхи хүснэгтээр харуулав.

Шалгалтын дүгнэлт

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 97,5%, хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 82,7%, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн мэдээ байршуулалт 93,8%, 6 байгууллага 61,205,639 (жаран нэгэн сая хоёр зуун таван мянга зургаан зуун гучин ес) төгрөгийн худалдан авалтыг огт байршуулаагүй нөхцөл байдал тогтоогдлоо.

Улирлын мэдээг хугацаа хоцроодог, огт илгээдэггүй, мэдээлэл дутуу байршуулдаг, оруулах мэдээлэл байхгүй гэж **Худал** мэдээлдэг зэрэг зөрчлүүд нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн хариуцлагагүй байдал, ажилдаа хайнга ханддаг, хугацааг нь тулган мэдээллээ дутуу хагас чанаргүй байршуулдаг, мөн мэдээлэл байршуулалтад тавих удирдлагын болон дотоод хяналтын тавих хяналтууд байхгүй, мөн цахим орчноос өөрсдөө хэрэгтэй мэдээллийг авдаггүй зэргээс үүдэлтэй гэж үзлээ.

Иймд цаашид төсвийн шууд захирагч нар шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, үүнд дотоод хяналтын нэгжийг татан оролцуулах, мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн ажлын хариуцлагыг сайжруулах, ажил дүгнэх үзүүлэлтэд харгалздаг болох, мэдээлэл байршуулж байгаа албан хаагчид шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн гүйцэд, үнэн зөв байршуулах, мэдээлэл хоорондын уялдааг хангаж ажиллах, мөн манай байгууллагын цахим хаягийг дагаж өөрсдийн хэрэгцээт мэдээллийг байнга авч ажллах шаардлагатай байна.

Байгууллагуудын цаашид анхаарах асуудлууд

1. Байгууллагын удирдлага болон дотоод хяналтын нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж байгаа мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв хуулийн хугацаанд байршуулж байгаа эсэхэд улиралд нэгээс доошгүй удаа хяналт тавих;

2. Байгууллагууд байршуулах ёстой мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв чанартай байршуулж хэвших;

3. Байгууллагууд улирлын мэдээ тайланг хуулийн хугацаанд илгээж хэвших;

4.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн мэдээ байршуулалтыг чанартай бүрэн сар бүр мэдээлж хэвших;

5. Улирлын мэдээг хугацаа хоцроож илгээсэн Баруунбаян-Улаан, Баянгол, Тарагт, Өлзийт, Гучин-Ус, огт илгээгүй Уянга, Хархорин сумдын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга нар цаашид дахин давтан гаргахгүй байхад анхаарч, холбогдох албан хаагчдыг арга зүй, мэдээ, мэдээллээр ханган ажиллаж хэвших;

6. Сумдын Засаг дарга нарын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.1.2.1 дэх заалтыг хариуцан ажиллах албан хаагчийг томилох, үр дүнг тооцох

7. Өгсөн үүрэг даалгавар болон зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах;